



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
22 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243
И-мэйл: agroecology@mul.s.edu.mn
Вэб сайт: www.mul.s.edu.mn

2023. 10. 03 № 01 / 269
танай _____ -ны № _____ -т

Хичээлийн хөтөлбөрт санал өгөх тухай

Тогтвортой хөгжил (Sustainable Development) ENVI502 хичээл нь өргөн хүрээний ойлголтыг хамрах учир тухайн салбаруудын онцлогийг шингээн, баяжуулах боломжтой юм. Тус төслийн хүрээнд бэлтгэж буй тогтвортой хөгжлийн тухай ойлголт нь хүрээлэн буй орчны ойлголтод суурилсан учир байгалийн нөхцөл, нөөцийн ашиглалт, орчны бохирдлын ойлголтуудыг голчлон тусгах хэрэгтэй гэж үзэж байна. Тус хичээлийн зорилгод тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг хангах бодлого төлөвлөлт хангах, олон улсын хамтын ажиллагааны механизмыг үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэсэн мэдлэг, чадвар эзэмшүүлэхээр заасан байна. Хичээлийн төлөвлөлтөд олон улсын хамтын ажиллагаа болон тогтвортой хөгжлийн чиглэлээр байгаль орчны зүгээс авч хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа, шинэ технологийн агуулга нэмэх хэрэгтэй. Семинарын хичээлүүдэд Монгол улсын зүгээс тогтвортой хөгжлийн чиглэлээр авч хийгдэж буй ажлуудад үнэлэлт дүгнэлт өгөх, олон улсын зүгээс хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг дүгнэх, ялангуяа бодлогын баримт бичгүүдтэй илүү танилцан, хэрэгжих боломж, нөхцөлийг дүгнэх нь хичээлийг ач холбогдлыг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Иймд хичээлийн нэр, агуулгын хувьд өөрчлөх санал байхгүй болно.

Хичээлийн төлөвлөгөөнд санал өгсөн:

Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн

Агроэкологийн сургуулийн

Ахлах багш *Д. Банзрагч* Д.Банзрагч, доктор